



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 09 өдөр

Дугаар A/170

Улаанбаатар хот

Г Заавар шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 67 дугаар тогтоолоор батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 3.1.4 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нүүдлийн хурал зохион байгуулах заавар”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Салбар болон орон нутгийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нүүдлийн хурал зохион байгуулах төлөвлөгөөний маягтын загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Салбар болон орон нутгийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нүүдлийн хурал зохион байгуулсан тайлангийн маягтын загвар”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Салбар болон орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисст даалгасугай.
3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс /П.Мөнхтулга/-т үүрэг болгосугай.
4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2015 оны “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нүүдлийн хурал зохион байгуулах заавар батлах тухай” А/36 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.





Ниймийн даатгалын өрөнхий газрын
дарьиin 2021 оны 1. сарын 09.-ний
өдрийн 11 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ КОМИССЫН НҮҮДЛИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Даатгуулагч (иргэн)-д эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээг хүртээмжтэй, жигд хүргэх зорилгоор алслагдсан сум, хороонд салбар болон орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэх үйл ажиллагааг “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нүүдлийн хурал” гэнэ.

1.2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нүүдлийн хурал /цаашид Нүүдлийн хурал гэх/-ыг орон нутгийн нэгдсэн эмнэлэгтэй сумдад болон “А” зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвийг түшиглэн зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд нүүдлийн хурлыг аймгийн төвөөс 200-аас дээш км алслагдсан, 3000-аас баагүй хүн амтай суманд зохион байгуулна.

1.3. Мэргэжлээс шалтгаалсан өвчиний эмнэлэг хөдөлмөрийн магадлах салбар комиссын нүүдлийн хурлыг даатгуулагч (иргэн)-ийн харьяалах үйлдвэр, уурхайн дэргэдэх сувилал, эмнэлгийн хэсгийг түшиглэн зохион байгуулна.

1.4. Нүүдлийн хурлыг зохион байгуулахдаа сум, хороо, багыг нэгтгэн, бүсчилсэн хэлбэрээр хамрах хүрээг тогтоож болно.

1.5. Нүүдлийн хурлыг батлагдсан төсөвт багтаан зохион байгуулна.

1.6. Салбар болон орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүд нь нийтийн эрх ашгийг дээдэлж, авилга, ашиг сонирхлын зэрчлөөс ангид байж, харилцан бие биеэ хүндэтгэж ажиллана.

Хоёр. Нүүдлийн хурал зохион байгуулах бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

2.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дарга нь нүүдлийн хурлын удирдамжийг баталж 30 хоногийн өмнө хурал зохион байгуулагдах сум, хорооны Засаг дарга бусад холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн байна.

2.2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь нүүдлийн хурал зохион байгуулах дараах бэлтгэл ажлыг хангасан байна. Үүнд:

- Үзлэгийн хуваарь гаргах;
- Нүүдлийн хурал зохион байгуулах байр, өрөө тасалгааг бэлдэх;
- Шаардлагатай оношилгоо, шинжилгээний багаж, тоног төхөөрөмжөөр хангах;
- ЭХМ-ын мэдээллийн сангийн программ хангамжийн хэвийн ажиллагааг хангах;
- Иргэдэд зарлан мэдэгдэх, бүрэн хамруулах;

2.3. Нүүдлийн хурлыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дарга эсхүл орлогч дарга удирдаж, комиссын гишүүдийн гуравны хоёроос дээш хувийн ирцтэйгээр зохион байгуулна.

2.4. Хяналтын эмч нь даатгуулагч (иргэн)-ийн өвчин, эмгэгийн байдал, үе шат, үйл ажиллагааны өөрчлөлт, алдагдлын зэрэг, холбогдох үзлэг, шинжилгээний дүн, дүгнэлт, хяналтын хугацаанд хийгдсэн эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээ



зэргийг тусгасан дүгнэлт бичиж, Эмнэлэг хяналтын комиссын болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хуралд танилцуулна.

2.5. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэсэн өмнөх шийдвэрийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө эсхүл хойно нүүдлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж болно.

2.6. Нүүдлийн хурлаар хэлэлцсэн даатгуулагч (иргэн)-ийн мэдээллийг эмнэлэг хөдөлмөрийн магадлалын цахим мэдээллийн санд бүртгэж, шийдвэрийн актад гишүүд гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулна.

2.7. Нүүдлийн хурал зохион байгуулах хугацаанд тухайн хурлын бүрэлдэхүүн сумын эмч наарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр сургалт зохион байгуулна.

2.8. Даатгуулагч (иргэн)-ийн эрхтэн, бие махбодийн тогтоц, үйл ажиллагаа хүндээр гэмтсэний улмаас өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй бусдын асаргаа, сувилгаа шаардлагатай болсон, байнгын хэвтэрт байгаа зэрэг тохиолдолд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоож болно.

2.9. Нүүдлийн хурлыг зохион байгуулахдаа “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-д заасан хурлын дэгийг нэгэн адил баримтлан ажиллана.

2.10. Нүүдлийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

2.11. Эмнэлэг хяналтын комиссгүй орон нутагт нүүдлийн хурал зохион байгуулахгүй.

2.12. Иргэдэд эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай хууль эрх зүйн баримт бичгийг танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулах.

Гурав. Нүүдлийн хурлын төлөвлөгөө, тайлан, хяналт

3.1. ЭХМК нь нүүдлийн хурал зохион байгуулах төлөвлөгөөг жил бүрийн нэгдүгээр сард багтаан Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын даргаар батлуулан мөрдөж ажиллана.


3.2. Нүүдлийн хурлын тайланг тоон мэдээний хамт Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисст 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор тайлagnана.

3.3. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс нь салбар болон орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоос ирүүлсэн тайланг нэгтгэн дүгнэж, дараа оны 2 дугаар сард багтаан Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

3.4. Нүүдлийн хурлын тайлан мэдээ, чанар, үр дүн, төсвийн зарцуулалт зэрэгт үндэслэн нүүдлийн хурлын төсөөт өөрчлөлт оруулж болно.

3.5. Нүүдлын хурлын явцад Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дарга байнгын хяналт тавьж алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.

3.6. Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгуулах зорилгоор хуурамч баримт бичиг үйлдсэн, үйлдэх зорилгоор комиссын гишүүдэд хууль бусаар нөлөөлсөн албан тушаалтан, аливаа этгээдэд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.





Нийгмийн даатгалын өрөнхий газрын
даргын 2021 оны 09-ний
өдрийн 11 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

..... САЛБАР БОЛОН ОРОН НУТГИЙН ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ
КОМИССЫН НҮҮДЛИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
..... ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

.....ОН.....САР.....ӨДӨР

№	Хурал зохион байгуулах сум, хорооны нэр	Хамрагдах сум, хорооны нэр	Хугацаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Үйл ажиллааны төсөв	Хамтран зохион байгуулах байгууллага
1							
2							
3							
4							

Төлөвлөгөө боловсруулсан: / /

гарын үсэг, тэмдэг нэр, албан тушаал

Төлөвлөгөөг хянасан: / /

гарын үсэг, тэмдэг нэр, албан тушаал



Нийгмийн даатгалын ерөнхий газрын
дэргүүн 2021 оны 11 сарын 09-ний
өдрийн 11 дугаар тушаалын гуравдугаар
хавсралт

..... САЛБАР БОЛОН ОРОН НУТГИЙН ЭМНЭЛГЭ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ
КОМИССЫН НҮҮДЛИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН ОНЫ ТООН МЭДЭЭ

№	Үзүүлэлтүүд	1	2	3	4	Нийт
1	Хурал зохион байгуулсан сумын нэр					
2	Хамрагдсан сумын нэр					
3	Хурал хийсэн огноо					
Үүнд:	Хурлаар хэлэлцсэн хүний тоо					
	ХЧА-ын хувийг хэвээр сунгасан					
	ХЧА-ын хувийг нэмэгдүүлсэн					
	ХЧА-ын хувийг бууруулсан					
	ХЧА-ын хувь цуцалсан					
	Хөдөлмөрийн нөхцөл сольсон					
	Ажлын цаг хорогдуулсан					
4	Хурлаар шийдвэрлээгүй буцаасан					
	5 Хуралд оролцсон гишүүдийн тоо					
	6 Хуралдсан цаг					
	Зарцуулсан зардал	Томилолтын зардал				
		Цагийн хөлс				
		Замын зардал				
8	Нүүдлийн хурлын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаарх санал					

Тайлан нэгтгэсэн: /

гарын үсэг, тэмдэг нэр, албан тушаал

Тайлан хянасан: /

гарын үсэг, тэмдэг нэр, албан тушаал

Тайлан нэгтгэсэн огноо: